

СТЭНФОРД АНГЛИ ХЭЛНИЙ АКАДЕМИ

Бид бүх зүйлийг чанартай хийж бүтээхийг эрмэлздэг, түүнчлэн Энэтхэгт Англи хэлний сургалтад сууж Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх хугацаанд тань мартхааргүй дурсамжуудыг бид танд үлдээх болно.

Стэнфорд Англи Хэлний Академид дэлхийн 50 орноос оюутнууд ирж суралцдаг. Гадаад оюутнууддаа туршлагатай хамт олон, чанартай үйлчилгээ, орчин үеийн тоног төхөөрөмж зэргээр хангаж мөн адал явдал, сайхан дурсамжыг үлдээнэ гэдгийг амлаж байна.

Яагаад САХА-д суралцдаг вэ?

Бидний тухай

САХА – ийн санал болгож буй сургалтууд

Тогтмол асуудаг асуултууд

Бидэнтэй холбоо барих

ЯАГААД САХА-Д СУРАЛЦДАГ ВЭ?

Бид мэргэшсэн багш нартай, сургалтын арвин их туршлагатай хамт олон:

- ✓ Үнэгүй интернэт хэрэглэх (WiFi) орчин
- ✓ Хэрэгцээнд тулгуурласан сургалтын материал, гарын авлага ашигладаг
- ✓ Нэг ангид суралцах оюутны тоо цөөн, Үйлдвэртэй танилцах боломжтой
- ✓ Үнэгүй Анимэйшн туршилтын өрөөтэй
- ✓ Оройн ангиуд ба ярилцлагын клубтэй
- ✓ Номын сантай, өдөр тутмын сонин, сэтгүүл байнга байдаг
- ✓ Системтэй, шинэ содон сургалтын заах аргатай
- ✓ Оюутны бие дааж суралцахад нь зориулсан англи хэлний CD – ROM материалуудтай
- ✓ Оюутны бие дааж суралцахад нь зориулсан авиа зүйн аудио бичлэгүүдтэй
- ✓ Онцгой зочин багш нар лекц орно, сургалтын үзүүлэх семинар зохиогдоно
- ✓ Анимейшны чиглэлээр зөвлөгөө өгөх уулзалт зохиогддог
- ✓ Натар бичих туршлага солилцох семинар, намтар хянах үйлчилгээ үзүүлдэг

Манай үйлчилгээнүүд

- ✓ Их дээд сургууль төгсөгчид, элсэгчдийг чиглүүлэх
- ✓ Ажил мэргэжлээ сонгоход зөвлөгөө өгөх
- ✓ Оюутнуудад зөвлөгөө өгөх, Суралцахад нь дэмжлэг үзүүлэх
- ✓ Цаашид суралцахад нь зөвлөгөө өгөх
- ✓ Дотуур байрыг олж, зохицуулж өгөх
- ✓ Виз авахад нь туслах
- ✓ Нисэх буудлаас тосч авах

БИДНИЙ ТУХАЙ

Ноён Ананд Такур,

Гүйцэтгэх захирал [CEO]

Мэндчилгээ: САХА нь суралцагч оюутнууддаа чанартай боловсрол эзэмшүүлдэг хамт олноороо бахархадаг. Манай сургуулийн англи хэлний төрөл бүрийн сургалтуудаас сонгон суралцаж, олон улсын оюутнуудтай мартагдашгүй цаг мөчийг өнгөрүүлэх болно. Холбоо барих: ceo@stanfordenglish.co.in

Хатагтай Кашиш Такур

Захирал,

Мэндчилгээ: САХА-ийн хамт олныг төлөөлөн миний бие оюутан та бүгдийг чин сэтгэлээсээ, халуун дотноор хүлээн авах болно, манай сургуульд элссэнээр оюутан та том хотод амьдрах, чадварлаг Академид суралцах зэрэг гайхамшигтай боломжуудыг олж авна. САХА-д оюутнууд зөвхөн багшаас суралцдаггүй, бие биенээсээ харилцан суралцдаг. Холбоо барих: info@stanfordenglish.co.in

Хатагтай Минал Кидар,

Элсэлт хариуцсан ажилтан

Холбоо барих: admin@stanfordenglish.co.in

Хатагтай Лата Такур ,

Макетингийн ажилтан

Холбоо барих: agent@stanfordenglish.co.in

Хатагтай Сална Рао,

Англи хэлний багш

Мэндчилгээ: Бид сургалтаа өөрсдийн харилцагчдынхаа англи хэлний харилцааны чадварыг дээшлүүлэх сургалт явуулсанаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба энэхүү сургалтын дүнд оюутнууд маань дэлхийн түвшинд амжилттай ажиллаж байгааг харх үнэхээр бахархалтай байдаг.

САХА-аас САНАЛ БОЛГОЖ БУЙ СУРГАЛТУУД

Эрчимжүүлсэн Англи хэл (2- 52 долоо хоног)

Суралцагчын Англи хэлний түвшин анхан эсвэл дээд түвшинд байгаа эсэхээс үл хамааран тухайн оюутны одоо байгаа түвшинг нь сайжруулах зорилготой зохигдсон энэхүү сургалт нь суралцагчдын гэрээсээ эсвэл ажил дээрээсээ дэлхий ертөнцтэй харилцах англи хэлний харилцааны чадварыг хөгжүүлэхэд туслах болно.

Академик Англи хэл (2- 52 долоо хоног)

Энэ сургалт нь их дээд сургуульд элсэхээр зорьж байгаа хүмүүст зориулагдсан. Энэтхэг улсад их дээд сургуульд элсэхэд Англи хэлний мэдлэг чадвар онцгой шаардлагатай. Энэ шаардагдаж буй англи хэлний чадварыг эзэмшиж, өөрийн түвшингээ бататгах гэж буй суралцагчдад энэ хөтөлбөр хамгийн тохиромжтой.

Мэргэжлийн харилцааны Англи хэл (2- 52 долоо хоног)

Бизнесийн харилцаанд шаардагдах хэл, харилцааны хамгийн чухал чадваруудыг хөгжүүлж, бизнесийн хүрээний мэдлэгээ тэлэхэд зориулагдсан сургалт юм. Энэ сургалт нь суралцагчдыг хүмүүстэй харилцах, тэдэнтэй утсаар холбогдох, уулзалт, илтгэл тавих үед өөртөө итгэлтэй, чөлөөтэй байх чадварт суралцуулахыг зорьдог.

IELTS-д бэлтгэх (2- 52 долоо хоног)

IELTS-н шалгалт өгөхөөр зорьж буй хүмүүст зориулсан сургалт. Энэ шалгалтыг Австрали, Их Британи, Канад, Ирланд, Шинэ Зеланд, Өмнөд Африкийн Их дээд сургуулиуд хүлээн зөвшөөрдөг. Суралцагчдыг сургалтаа дууссаны дараа Пийрсоны дадлагын тестүүдээр (үнэгүй) хангах болно. Тавигдах шаардлага: суралцагч нь дор хаяж англи хэлний дунд түвшний мэдлэгтэй байх хэрэгтэй.

Сургалт, аялалын хөтөлбөр, Зуны нэмэлт сургалт (7 хоногоос – 1 сар)

Оюутнуудад: Уг хөтөлбөр нь 1 сарын хугацаатай. Оюутнууд нь САХА-аас зохион байгуулдаг англи хэлний сургалтуудаас аль хүссэнээ сонгон суралцаж, амралтын өдрүүдээр аялалаар явна.

Байгууллага хамт олонд: Бид тухайн оролцогч хамт олны санал дээр үндэслэн тусгайлан зохиосон хөтөлбөрүүдийг санал болгодог. Та САХА-аас санал болгож буй аль нэг англи хэлний сургалтаас сонгон суралцах ба Энэтхэг улсын хэсэг болгоны өөр хоорондоо харилцан адилгүй соёлтой танилцах боломжтой. Үүнээс гадна нэг өдрийн үйлдвэртэй танилцах аялал багтсан. Энэ хөтөлбөр нь 7 хоногоос 1 сарын хугацаанд байхаар зохиогдох боломжтой.

Хос сертификатын сургалт (4- 52 долоо хоног)

Уг сургалт нь Англи хэл, Энимэйшний мэдлэгээ дээшлүүлэхийг хүсч буй хүн бүрт зориулагдсан хосолсон сургалт юм. **Оюутанд тавигдах шаардлага:** компьютерийн суурь мэдлэгтэй байх ёстой.

Гадаад хэл (Франц хэл) (2- 52 долоо хоног)

Гадаад хэлний сургалтыг манай туршлагатай багш нар хөтлөн явуулдаг. Бид Франц хэлний шинжлэл, авиа зүй, дүрэм, үгсийн сан, өдөр бүр хэрэглэгддэг хэрэглээний Франц хэлийг танд заана. **Оюутанд тавигдах шаардлага:** онцгой шаардлага тавихгүй.

Хичээл эхлэх өдөр: Даваа гариг бүр

Анги дүүргэлт: 15 оюутнаас илүүгүй, суралцагчдын нас нь 15-30 хооронд.

ТОГТМОЛ АСУУДАГ АСУУЛТУУД

1. ***САХА- д хэрхэн элсэх вэ ?***

www.stanfordenglish.co.in сайтнаас онлайн өргөдлийн маягтыг татан авч бөглөөд, өөрийн суралцахыг хүсч буй сургалтын нэр, холбоо барих хаяг зэрэг чухал мэдээллүүдээ бичсэн эсэхээ сайтар нягталаад бидэнд илгээнэ. Манай ажилтан нар 24 цагийн дотор танд хариу мэдэгдэх болно.

2. ***Бүртгэлийн үйл явц яаж явагдах вэ ?***

Таны илгээсэн өргөдлийн маягтыг хүлээн авсан манай элсэлт хариуцсан ажилтан 24 цагийн дотор танд сургалт, төлбөр зэрэг шаардагдах мэдээллүүдийг агуулсан захиаг танд явуулна. Ингээд таны төлбөр төлөгдсөний дараа бид 2-3 ажлын өдарт багтаан танд урилга илгээнэ.

3. ***Байрны асуудлыг шийдвэрлэж өгдөг үү ?***

Тийм. Сургуулиас 15 минут яваад хүрэх зайд байрлах оюутны дотуур байрнууд олон сонголттойгоор байдаг.

4. ***Нисэх буудлаас тосч авдаг уу?***

Тийм. Та өргөдлийн маягтаа бөглөж байх үедээ бид таныг нисэх буудлаас тосч авах шаардлагатай эсэхийг дурьдах хэрэгтэй.

5. ***Би сургалт эхэлсэний дараа өөр сургалт сонгож болох уу ?***

Тийм. Та ямар ч үед сургалтын төрлөө өөрчилж болно. Гэсэн хэдий ч сургалтын төрөлөө солихоос өмнө тухайн сургалтанд тавигдах хэлний шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох тест өгөх шаардлагатай.

6. ***Би 3 сарын хугацаатай Бизнесийн англи хэлний сургалтыг сонгосон. Би Сургалт, Аялалын ангийн аялалд хамрагдаж болох уу?***

Болно. Аялал амралтын өдрүүдэд зохион байгуулагддаг учраас та хүсвэл хамрагдах бүрэн боломжтой. Гэсэн хэдий ч аялал бүрт багахан хэмжээний төлбөр төлөх шаардлагатай. Төлбөрийг манай оюутан хариуцсан ажилтнуудаас лавлах хэрэгтэй.

7. ***Сургалтаа төгсөөд Сертификат авах уу ?***

Тийм. Төгсөлтийн шалгалтыг амжилттай өгсөн, 80% дээш хувийн ирцтэй төгсөгчдөд сертификат олгоно.

8. ***Англи хэлний сургалттайгаа хамт бусад сургалтуудад хамрагдаж болох уу?***

Бид Англи хэл нэмэх нь Энимэйшн, Вэб дизайн, Мэдээллийн технологи, Game art & design, Hospitality, Жижиглэн худалдаа зэрэг хос сертификатын сургалтыг явуулдаг. Гэсэн хэдий ч та бусад сургалтуудад хамрагдах эсвэл өөрийн сургуульд элсэх хүсэлтэй байгаа бол бид танд туслахдаа таатай байх болно. Манай Ирээдүйн жим хөтөлбөртэй танилцаарай.

9. Би гадаад оронд суугаа боловсролын төлөөлөгч байна. Би танай сургалтын байгууллагыг оюутнууддаа санал болгож болох уу?

Тийм. Та манай байгууллагад оюутан элсүүлж болно. Та манай байгууллагын вэб хуудас дээрх ‘becoming our agent’ хэсэгт зочилоод шаардагдах мэдээллийг бөглөн илгээнэ үү. Манай маркетингийн баг танд 24 цагийн дотор хариу мэдэгдэх болно. Эсвэл та ажлын өдрүүдэд буюу Даваагаас Баасан гаригт 10:00-18:00 цагийн хооронд утсаар холбогдож болно. Мумбайн цагийн бүс GMT +5:30.

10. Энэтхэгт сурахад ямар виз хэрэгтэй вэ?

Сурах зорилгоор ирж буй тохиолдолд Сургалтын визтэй байх ёстой. Та өөрийн орон дахь Энэтхэг улсын Элчин сайдын яам, Цагаачлалын албанд хандана уу.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ ХАЯГ

СТЭНФОРД АНГЛИ ХЭЛНИЙ АКАДЕМИ

1201, Соннэт, Кисар Хармони,
Плотын дугаар 11&12, Сектор-6,
Харгар, Нави Мумбай 410210
Махараштра муж, Энэтхэг улс

Телефон: + 91 22 6721 5522

И-мэйл: info@stanfordenglish.co.in

Вэб хуудас: www.stanfordenglish.co.in